

Нисдэг хэрэгслүүдийг нарийн тодорхойлох нь

2019 оны 12-р сар

Сүүлийн үед жолоочгүй агаарын төхөөрөмж болон системийг (дрон) төрөл бүрийн зорилгоор түгээмэл ашигладаг болсон. Шоу тоглолтоос гадна үйлдвэрлэл, ХАА, байгаль орчны судалгаа, шинжилгээ, мониторинг, хэрэгжүүлэлт зэрэгт нүдэн үзлэг явуулахын тулд тэдгээрийг хуулийн дагуу ашигладаг. Одоо тэдний тоо хэмжээ чөлөөт нислэгийн модель шиг олон болох төлөвтэй байна.

Харин нэг санаа зовоосон асуудал бол үйлдвэрлэлийн талбайд дроныг ашигласнаар тоног төхөөрөмж мөргөх, гэмтээх, гал болон дэлбэрэлт ч үүсэх боломжтой. Саяхан гэхэд боловсруулах үйлдвэрт цэргийн дронтой холбоотой осол тохиолдсон.

Баяр ёслолын үеэр агаарын пуужин, салют зэрэг тэсэрдэг хэрэгслүүд нь шатамхай материал хадгалдаг, ашигладаг талбайд унаж, гал ноцоож болзошгүй.

Зарим тохиолдолд галтай бөмбөлгийг (нисдэг дэнлүү гэх мэт) салютын оронд хэрэглэдэг. Энэ ч бас галын эх үүсвэр болох боломжтой бөгөөд мөн илүү алс зайд нисдэг. Үүнтэй холбоотой нэг тохиолдол бол халуун хийн бөмбөлөг нисгэж байсан хүмүүс бөмбөлгийг үйлдвэрийн талбай руу орохыг зогсоож чадаагүй учир бөмбөлөг үйлдвэр дотор орж аваарын буулт хийсэн аж. (доорх зураг болон 2007 оны 4-р сарын Beacon: [Mr. Potato Head is Down](#)-ыг харна уу.



Та мэдэх үү?

- Дээрх бөмбөлөгтэй холбоотой тохиолдлын үед хэдийгээр ийм зүйлийг хэн ч төсөөлж байгаагүй боловч аврах ажиллагааны сургалт, туршлага, дадлага сайн байсны ачаар талбайн ажилчид аваарын ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн.
- Механик гэмтэл ба галын шууд аюул эрсдлээс гадна дээгүүр нисэж буй техник агаарт байрлах тусгаарлагагүй цахилгааны шугамтай хүрэлцэж богино холболт үүсэх зэрэг үр дагавар учруулах боломжтой. Ийм төрлийн мэдээлэл ихэвчлэн метал гадаргуугай мөнгөлөг цаасаар хийж, шингэн гель дүүргэдэг гоёлын бөмбөлөгтэй холбоотой байдаг.

Та юу хийж чадах вэ?

- Та талбайд хяналтын үзлэг хийхдээ тэнгэрийг ч бас ажиглан шалга.
- Үйлдвэрийн талбай дээгүүр нисэж болзошгүй бүх аюултай зүйлийн талаар мэдээл. (Үүнд мэдээж шувуу багтахгүй.)
- Ялангуяа галын наадам, нисдэг дэнлүү, халуун хийн бөмбөлөг хөөргөдөг улирлын үеэр сэрэмжтэй бай.
- Таны амьдардаг газрын ойролцоо химийн үйлдвэр, түлшний агуулах эсвэл төстэй байгууламж байдаг бол хөршүүддээ галын наадам, дрон нисгэхээс нь өмнө холбогдох аюул эрсдлийн талаар зөвлөгөө өг.
- Хэрэв танай байгууламжид дрон ашигладаг бол бусад хэвийн бус үйл ажиллагааны адил зөвшөөрөл авсан байх ёстой.

“Бүх сайн, төгс бэлэг дээд тэнгэрээс өгөгддөг” – гэвч зарим аюул ч бас тэндээс ирдэг шүү!

© AIChE 2017. Зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан. Арилжаа, худалдааны бус харин сургалтын зорилгоор хуулбарлаж ашиглахыг дэмжинэ. Харин арилжаа, худалдааны зорилгоор AIChE –с бичгээр илэрхийлсэн зөвшөөрөл аваагүй тохиолдолд хуулбарлаж ашиглахыг хатуу хориглоно. Бидэнтэй ccps.beacon@aiche.org эсвэл 646-495-1371 хаягаар холбогдоно уу.